

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/024/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-3047	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Б.Батмөнх Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ж.Баясгалан Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn
--	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ХҮДЭР ОЙН АНГИ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Т.МӨНХТУУЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 011-2025/024) ИА-СТА-011041
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хүдэр ойн анги” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хүдэр ойн анги” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8,080,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэн хөрөнгөд бүртгэж авсан байна.

Аудитын гол асуудал

Сумын ИТХ-аар тус байгууллагын орлогын төлөвлөгөөг батлахдаа дансны эхний үлдэгдлийг нэмж тооцон баталсан байна. Ингэхдээ дансны бодит үлдэгдлээс 1,320.9 мянган төгрөгөөр бага буюу 149,900.0 мянган төгрөгөөр тооцож баталсан. Тайлант онд төсвийн тодотгол хийгдээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	182,219,938.13	67,643,141.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	151,220,930.40	27,151,468.03
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	151,220,930.40	27,151,468.03
31210	Төгрөг	151,220,930.40	27,151,468.03
31213	Арилжааны банк дахь харилцах	151,220,930.40	27,151,468.03
33	АВЛАГА	1,013,581.56	817,820.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,000.00	100,000.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	-	10,000.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	813,581.56	707,820.48
35	БАРАА МАТЕРИАЛ	29,985,426.17	39,673,852.52
35400	Хангамжийн материал	29,985,426.17	39,673,852.52
35420	Аж ахуйн материал	4,691,826.91	9,109,636.91
35470	Бусад хангамжийн материал	25,293,599.26	30,564,215.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	71,039,634.34	79,633,198.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	71,039,634.34	79,633,198.40
39200	Биет хөрөнгө	69,992,967.66	79,109,865.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,921,066.82	49,921,066.82
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,369,048.80)	(10,361,155.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,701,808.87	22,281,493.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,078,765.03)	(10,560,564.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,898,370.00	24,200,370.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,080,464.20)	(7,520,634.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	23,248,815.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,099,526.96)
39300	Биет бус хөрөнгө	1,046,666.68	523,333.36
39301	Программ хангамж	1,570,000.00	1,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(523,333.32)	(1,046,666.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	253,259,572.47	147,276,339.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	457,922.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	457,922.20
41300	Өглөг	-	457,922.20
41360	Бусад өглөг	-	457,922.20
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	457,922.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	253,259,572.47	146,818,417.23
51	Засгийн газрын хувь оролцоо	253,259,572.47	146,818,417.23
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,900,942.97	78,804,956.01
51200	Хуримтлагдсан үр дүн	229,358,629.50	59,933,461.22
51210	Өмнөх үеийн үр дүн	130,611,349.12	174,454,616.46
51220	Тайлант үеийн үр дүн	98,747,280.38	(114,521,155.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	8,080,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	253,259,572.47	147,276,339.43

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	199,102,944.00	115,632,302.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,102,944.00	115,632,302.87
120	Нийтлэг татварын бус орлого	199,102,944.00	115,632,302.87
120002	Хүүгийн орлого	-	1,015,302.87
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	199,102,944.00	114,617,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	100,355,663.62	230,153,458.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,355,663.62	230,153,458.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,355,663.62	230,153,458.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,370,090.34	217,616,521.85
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	92,370,090.34	217,514,991.54
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	-	101,530.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,985,573.28	12,536,936.26
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,985,573.28	12,536,936.26
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	98,747,280.38	(114,521,155.24)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	98,747,280.38	(114,521,155.24)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Үзүүлэлт
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,900,942.97	-	130,611,349.12	154,512,292.09	23,900,942.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,900,942.97	-	130,611,349.12	154,512,292.09	23,900,942.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	98,747,280.38	98,747,280.38	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,900,942.97	-	229,358,629.50	253,259,572.47	23,900,942.97
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	23,900,942.97	-	229,358,629.50	253,259,572.47	23,900,942.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(54,904,013.04)	(54,904,013.04)	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,900,942.97	-	174,454,616.46	198,355,559.43	23,900,942.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	8,080,000.00	-	8,080,000.00	-

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	54,904,013.04	-	-	54,904,013.04	54,904,013.04
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(114,521,155.24)	(114,521,155.24)	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,804,956.01	8,080,000.00	59,933,461.22	146,818,417.23	78,804,956.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	199,946,337.00	115,622,302.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,946,337.00	115,622,302.87
120	Нийтлэг татварын бус орлого	199,946,337.00	115,622,302.87
120002	Хүүгийн орлого	843,393.00	1,015,302.87
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	199,102,944.00	114,607,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,518,613.98	226,641,265.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,518,613.98	226,641,265.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,518,613.98	226,641,265.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	73,630,431.00	106,633,346.00
210106	Ажилчдад төлсөн /ТӨҮГ/	73,630,431.00	106,633,346.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,178,803.00	31,798,270.93
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	9,178,803.00	31,798,270.93
2104	Хангамж, бараа материалын зардал	56,569,968.86	50,120,151.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	26,604,813.86	15,896,496.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	29,965,155.00	34,223,655.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,139,411.12	38,089,497.31
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,343,761.48	12,456,197.31
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	25,795,649.64	25,633,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	32,427,723.02	-111,018,962.37
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	13,050,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	13,050,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	13,050,500.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	0	13,050,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-13,050,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	32,427,723.02	-124,069,462.37
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,793,207.38	151,220,930.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	151,220,930.40	27,151,468.03

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Оны эхний үлдэгдэл	м/төг	149,900,000.00	151,220,930.40	-	-
2	Нийт орлого	м/төг	280,968,974.00	266,843,233.27	14,125,741.00	94.97
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	269,900,000.00	259,445,430.40	(10,454,569.60)	96.10
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	11,068,974.00	7,397,802.87	(3,671,171.00)	66.83
3	Нийт зардал	м/төг	280,968,974.00	239,691,765.24	(41,277,209.00)	85.00
	Үүнээс:					
	а) Борлуулалт, маркетингийн зардал	м/төг	96,500,000.00	52,567,094.00	(43,932,906.00)	54.47
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	184,468,974.00	187,124,671.24	2,655,697.24	101.44
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг	-	-	-	-
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	м/төг	-	27,151,468.03	(27,151,468.03)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь “Ойгоос бэлтгэх хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай модыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийлгэх, модны үр, тарьцыг бэлтгэх, зэрлэг ан амьтныг хамгаалах” гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Ойгоос бэлтгэх модны талбайг тусгаарлах,
- Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох,
- Мод бэлтгэсэн талбай болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойг эрүүлжүүлэх, ойжуулалтын ажил хийх, ойн хөнөөлт хортон шавж, өвчний тоймчилсон судалгааг хийх,
- Модны үр, тарьц бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг эрхлэх,
- Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллах,
- Аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох,
- Ойн санд амьдардаг зэрлэг ан амьтадыг хамгаалах, өсгөн үржүүлэх, улсын ойн санд таримал ойг хүлээн авах,

- Ойн дагалт баялгийн цаг хугацааны судалгааг хийх, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хэмжээг тогтоох гэх мэт

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг Даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,983.1 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	151,220.9	27,151.5	(124,069.4)
Авлага	1,013.6	817.8	(195.8)
Бараа материал	29,985.4	39,673.8	9,688.4
Үндсэн хөрөнгө	71,039.6	79,633.2	8,593.6
Нийт хөрөнгийн дүн	253,259.5	147,276.3	(105,983.2)
Өр төлбөр		457.9	457.9
Эздийн өмч	23,900.9	78,804.9	54,904.0
Хуримтлагдсан ашиг	229,358.5	59,933.5	(169,425.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	8,080.0	8,080.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	253,259.4	147,276.3	(105,983.1)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27,151.5 мянган төгрөг болж 124,069.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 27,151.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, холбогдох зардлыг өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 29,985.4 мянган төгрөг нь тайлант оны худалдан авалт, зарцуулалтын зөрүү болох 9,688.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 39,673.8 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 79,633.2 мянган төгрөг болж 8,593.6 мянган төгрөгөөр өссөн нь контейнер, хөлдөөгч, бутлагч машин, мотор зэрэгийг худалдан авсантай холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаар захирамжаар тус байгууллагын 2024 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг буюу нийт орлого, зарлагыг тус бүр 280,968.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөнд өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг орлогын төлөвлөгөөнд тусган буруу төлөвлөсөн байна.

Үүнээс шалтгаалан өмнөх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 151,220.9 мянган төгрөгийг орлогын гүйцэтгэлд тайлагнаж үндсэн үйл ажиллагааны орлогоос 259,445.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 7,397.8 мянган төгрөг,

нийт 266,843.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 239,691.7 мянган төгрөгийн зардал гаргасан гэж тайлагнасан байна.

Бодит гүйцэтгэлээр 115,632,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 14,125.7 мянган төгрөгөөр тасалсан нь 1200 га талбайд тусгаарлалт хийх төлөвлөгөөг 206 га талбайгаар дутуу хийснээс шалтгаалсан байна.

Нийт зардлыг 280,968.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 239,691.7 мянган төгрөгийг зарцуулж, зардлыг 41,277.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь мод үржүүлэг, ойжуулалт, бичиг хэрэг зэрэг зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 167,518.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **1,675.1**

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь 2024 оны төлөвлөсөн зардал 280,968.9 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр 239,691.7 мянган төгрөг зарцуулж, 41,277.2 мянган төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 166 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа,
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 1 удаа,

Огт мэдээлээгүй:

- Дараа жилийн зорилтот түвшин,
- Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг жилийн эцсээр огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудагс тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 174 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад гавьяат тариаланч Л.Цандэлэг, аймгийн хурц арслан Д.Төрболд, үндэсний сурын харвааны аймгийн мэргэн Ж.Эрхэмбаяр нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1,500.0 мянган төгрөгийн хандив тусламж үзүүлсэн төлбөрийн актын биелэлтийг хангаж ажилласан тул биелэлтийг 100.0 хувиар тооцлоо.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,500.0	1		1,500.0
Нийт дүн	1	1,500.0	1		1,500.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 14,125.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөвлөмж өгөв.

5.1 Зөвлөмж

Илрүүлсэн нь: Сумын тус газрын 2024 оны орлогын төлөвлөгөөнд өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 151,220,9 мянган төгрөгийг тайлант жилийн орлогод нэмж, нийт 280,968.9 мянган төгрөгөөр батлуулсан байна.

Аудитын явцад дээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хасч, бодитоор тооцоход 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг 14,125.7 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон "2024 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө"-г зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орлого зарлагын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтын дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага албан шаардлага		Хууль, хяналтын шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны сөнгөн хөрөнгийн үлдэгдлийг орлогын төлөвлөгөөнд нэмж баталсан, батлагдсан төлөвлөгөөг тасалсан.	1	14,125.7					1	14,125.7				
Дүн	1	14,125.7					1	14,125.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй	1	-						1 -
Нийт дүн	1	-						1 -